

Хүндэт Эцэг эх, Асран хамгаалагч танаа,

Манай сургууль Виржиниагийн Эрүүгийн Эрх Зүйн Үйлчилгээний Алба, Виржиниа мужийн Боловсролын Яамтай хамтран Виржиниагийн Сургуулиудын Уур Амьсгал, Ажлын байрны нөхцөлийн судалгааг хийж байна. Бид 2024 оны 1-р сараас эхлэн 9, 10, 11, 12-р ангийн сурагчид, ангийн багш, ажилтнуудын дунд санал асуулга явуулах юм. Сурагчдын санал асуулгын зорилго нь сургууль тус бүрийн сурагчдын дэмжлэг, сурагчдын оролцоо, сургуулийн дэг журам, аюулгүй байдлын нөхцөлийг тандахад оршиж байна. Цугларсан мэдээлэл нь аюулгүй, сургалт хүмүүжлийг дэмжсэн сургалтын орчинг бүрдүүлэхүйц боловсролын сургалт үйлчлэгэнд чиглүүлэхэд ашиглагдах болно.

Сурагчдын санал асуулгыг 1-р сарын 30-аас 2-р сарын 2-хооронд гүйцэтгэнэ. Санал асуулгад таны хүүхдийн нэрийг асуухгүй бөгөөд бүх хариулт нь нэргүй байна. Таны хүүхэд санал асуулгын асуултуудад хэрхэн хариулсныг багш, удирдах ажилтан юм уу өөр хэн нэгэн мэдэх боломжгүй. Мөн та хүүхдийнхээ санал асуулгын хариултуудыг харах боломжгүй юм. Та дараах вэбсайтад буй сурагчдын санал асуулгын асуултуудыг урьдчилан харж болно: <https://tinyurl.com/VaSchoolSurvey>.

Санал асуулгаар сурагчид сургуулийнхаа талаар ямар бодолтой явдаг, сурагчид бие биетэйгээ болон багш нартайгаа хэрхэн ойлголцож харилцдаг, сурагчид сургуулийн дүрэм журмын талаар ямар бодолтой байдаг, багш нарын сурагчдад туслах эрмэлзлийн талаарх асуултуудыг асуух болно. Тус санал асуулгад мөн дээрэлхэлт, сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлолт зэрэг зарим нэгэн хүнд байж болох сэдвүүд багтаж байгааг анхаарна уу. Энэ нь хүүхэдтэйгээ эдгээр чухал сэдвүүдээр ярилцах тохиромжтой цаг үе байж болох юм. Эдгээр сэдвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд, эх сурвалжуудтай <https://tinyurl.com/MentalHealthdcjs> эсвэл <https://tinyurl.com/VDOEstudentservices> үзнэ үү. хаягуудаас тус тус танилцана уу.

Танай хүүхэдтэй нэг ангийн түвшинд буй бүх сурагчид санал асуулгад оролцох боломжтой. Санал асуулга нь сайн дурын бөгөөд та болон/эсвэл таны хүүхэд оролцохгүй байхаар шийдэж болно. Таны хүүхэд оролцоогүй тохиолдолд таны, танай хүүхдийн юм уу танай сургуулийн эсрэг ямар нэгэн арга хэмжээ авахгүй. Хэрэв та хүүхдээ оролцуулахыг хүсэхгүй байгаа бол сургуулийнхаа оффист утсаар, имэйлээр эсвэл бичгээр **DATE**-ээс өмнө мэдэгдэнэ үү.

Виржиниагийн сургуулиудын санал асуулгын үр дүнг хичээлийн жилийн эцэс орчимд сургуульд илгээнэ. Та өөрийн сургууль, дүүрэгт хамаарах санал асуулгын үр дүнг эндээс харж болно: <https://tinyurl.com/VaSchoolSurvey>. Үр дүнг сургууль, дүүрэг, мужийн түвшинд ашиглах ба бидэнд буй давуу талуудаа тодорхойлох, таны хүүхэд болон мужийн нийт сурагчдын сурах орчинг сайжруулахад шаардлагатай бидит хэрэгцээг шийдвэрлэхэд ашигладаг.

Виржиниагийн сургуулиудын энэхүү чухал судалгаанд хамтран ажилласан танд баярлалаа.

{Signed by principal- Захирлын гарынүсэг}